



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 276

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд эрчим хүчний салбарт бий болсон, барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах Улсын комиссын актаар хүлээн авсан, 16 нэрийн нийт 796,067,951.00 (долоон зуун ерэн зургаан сая жаран долоон мянга есөн зуун тавин нэгэн) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Ховд цахилгаан түгээх" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Эрчим хүчний хөгжлийн төвийн захирал Я.Нямжаргал, "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Ганхүлэг, "Ховд цахилгаан түгээх" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ш.Арстан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001392

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн
276... дугаар тогтоолын хавсралт

**"ХОВД ЦАХИЛГААН ТҮГЭЭХ" ХХК-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Марк, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
					Төгрөгөөр	
1. "Баян булаг хүүхдийн зусланг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамтай холбох" /Ховд, Жаргалант сум/						
6кВ-ын ЦДАШ 20.1км						
1	АС утас	АС 50/8	метр	60,300	2,500.00	150,750,000.00
2	Төмөр бетон тулгуур	УКШ	ш	224	950,000.00	212,800,000.00
3	Хэт хүчдэл хязгаарлагч төмөр хийц /Хөндийрүүлэгч, Серьга, Ушко, Скоб/	-	ком	207	830,000.00	171,810,000.00
4	Газардуулга /Төмөр хийц/	-	ком	207	125,000.00	25,911,114.00
Дүн					1,907,500.00	561,271,114.00
6кВ-ын гаргалгааны ячейк						
5	6кВ-ын гаргалгааны ячейк	KYN28	ком	1	27,417,039.00	27,417,039.00
6	Реле хамгаалалт	Sel 751 A	ком	1	6,000,000.00	6,000,000.00
7	3 фазын тоолуур	DDSD22	ком	1	950,000.00	950,000.00
Дүн					34,367,039.00	34,367,039.00
6кВ-ын ЦДКШ 1.75км						
8	6кВ-ын кабель	3*185 мм2 XLPE	метр	1,750	69,075.00	120,881,595.00
9	Элс	УКШ-12.35.19	м3	204	8,250.00	1,686,300.00
10	Тоосго	-	ш	14,335	350.00	5,017,250.00
11	Мувьт	-	ком	6	247,000.00	1,482,000.00
Дүн					324,675.00	129,067,145.00
6/04кВ-ын 250кВА чадалтай дэд өртөө КТПН						
12	Дэд өртөө	КТПН	ком	1	17,500,000.00	17,500,000.00
13	Ачаалал тастагч, гал хамгаалагч, цэнэг шавхагч тоолуур	ПКТ 101, ОПН-10	ком	1	4,034,649.00	4,034,649.00
14	Трансформатор	S11-M-250/6	ш	1	10,800,000.00	10,800,000.00
15	Газардуулга /Төмөр хийц/	40x4.ф18	ком	1	4,500,000.00	4,500,000.00
Дүн					36,834,649.00	36,834,649.00
0.4кВ-ын ЦДКШ 1.25км						
16	0.4кВ-ын кабель	3*701*35	метр	1,250	27,622.00	34,528,005.00
Дүн					27,622.00	34,528,005.00
Нийт дүн:						796,067,951.00
						(долоон зуун ерэн зургаан сая жаран долоон мянга есөн зуун тавин нэгэн)